

---

**МОНГОЛ УЛСЫН КОВИД-19 ТӨСӨЛ (# Р173799), БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН  
(Р174571), КОВИД -19 ВАКЦИНЖУУЛАЛТЫН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН (Р175730)  
ТӨСӨЛ**

**МОНГОЛ УЛСЫН КОВИД-19 ТӨСӨЛ (# Р173799), БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН  
(Р174571), КОВИД -19 ВАКЦИНЖУУЛАЛТЫН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН (Р175730)  
ТӨСӨЛ**

**ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Эрүүл мэндийн яам

2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

## Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
1. Ерөнхий мэдээлэл, төслийн тухай.....	4
Үндэслэл.....	7
2. Оролцогч талуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх .....	8
2.1 Арга зүй, зарчим.....	9
2.2 Нөлөөлөлд өртсөн талууд .....	9
2.3 Бусад сонирхогч талууд .....	11
2.4 Эмзэг бүлэг.....	11
3.Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ).....	12
3.1 Төсөл боловсруулах явцад талуудын оролцоог хангасан байдал-тойм.....	12
3.2 Талуудын оролцоог хангах арга хэрэгсэл.....	13
3.3 Оролцогч талуудад мэдээлэл түгээх стратеги .....	14
3.4 Талуудын оролцоог хангах төлөвлөгөө .....	19
3.5 Эмзэг бүлгийн оролцоог хангах нь .....	20
4. Талуудын оролцоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөөц ба үүрэг .....	21
4.1. Нөөц .....	21
4.2. Удирдлагын чиг үүрэг, хариуцлага .....	22
5. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизм (ӨГШМ).....	22
5.1 Өргөдөл гомдол шийдвэрлэх механизмын тодорхойлолт.....	22
6. Хяналт, эргэх холбоо ба тайлан.....	25
6.1. Хяналтын үйл ажиллагаанд талуудын оролцоо.....	25
6.2. Талуудад эргэн мэдээлэх .....	25

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЗӨ	Амьсгалын Замын Өвчин
БОНУХ	Байгаль Орчны Нийгмийн Удирдлагын Хүрээ
ВББҮХ/VIRAT	Вакцины бэлэн байдлын үнэлгээний хэрэгсэл
ВББҮХ/VRAF	Вакцины бэлэн байдлыг үнэлэх хүрээ
ГГҮ	Гүйцэтгэлийн Гол Үзүүлэлт
ДБ	Дэлхийн Банк
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖСХ	Жендерт суурилсан хүчирхийлэл
ЗӨСҮТ	Зоонозын Өвчин Судлалын Үндэсний төв
ЗСӨ	Зүрх судасны өвчин
ЗТХЯ	Зам тээвэр хөгжлийн яам
ИНБ	Иргэний нийгмийн Байгууллага
МҮОНРТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
НОК	Нийслэлийн Онцгой Комиссын
НТХН	Нэгдсэн Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НЭМҮТ	Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий Газар
ОУ	Олон улс
ӨГШМ	Өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизм
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ТВ	Телевиз
ТНБ	Төслийн Нөлөөллийн Бүс
ТОХТ	Талуудын оролцоог хангах төлөвлөгөө
ТУЗ	Төслийн Удирдах Зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
УОК	Улсын Онцгой Комисс
ХАБЭА	хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
ХМТ	Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө
ХӨСҮТ	Халдварт Өвчин Судлалын Үндэсний төв
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ШӨХТ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө
ЭМХТ	Эрүүл Мэндийн Хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭХЭМҮТ	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв

## Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)

2021 оны нэгдүгээр сар

### 1. Ерөнхий мэдээлэл, төслийн тухай

2019 оны шинэ коронавирусаас үүдэлтэй коронавирусын халдвар (КОВИД-19) 2019 оны 12-р сараас эхлэн Хятадын Хубэй мужийн Ухань хотоос бараг бүх улс орон даяар дэлхий даяар эрчимтэй тархаж, халдварын тархалт 109 сая гаруй тохиолдол бүртгэгджээ. КОВИД-19 бол хүн төрөлхтөнтэй холбоо бүхий амьтдаас сүүлийн хэдэн арван жилд гарч ирсэн хэд хэдэн халдварт өвчний дэгдэлтийн нэг бөгөөд үүнээс үүдэн нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт томоохон нөлөө үзүүлж байна.

2021 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар Монгол Улсад КОВИД-19-ийн батлагдсан 2383 тохиолдол бүртгэгдсэнээс 1545 нь Улаанбаатарт, мөн Сэлэнгэ, Дархан-Уулд халдвар дамжсан болох нь тогтоогдсон бөгөөд сувилагч, эмч нар үүргээ гүйцэтгэж байхдаа халдвар авсаар байна. 2021 оны 02 сарын 15-ны өдрийн байдлаар эдгэрсэн 1711, эмчилгээ хийлгэж буй 655 өвчтөн байгаа; Үүнээс маш хүнд 1, хүнд 3, хүндэвтэр 86, хөнгөн 565 байна. 2020 оны 1-р сарын 3-нд гарал үүсэл нь тодорхойгүй уушгины хатгалгааны талаар мэдээлснээс хойш ЭМЯ бэлэн байдлыг хангах чиглэлээр ДЭМБ, олон улсын түншүүд болон эрүүл мэндийн бус салбарын оролцогч талуудтай хамтран ажиллаж байна.

Шийдвэр гаргах, КОВИД-19 хариу арга хэмжээний үндэсний төлөвлөгөөг шинэчлэх зорилгоор Монгол Улсад шинэ Коронавируст халдвар (Ковид-19) хүн амын дунд тархах эрсдэлийн салбар дундын үнэлгээг 21 удаа зохион байгуулаад байна. Хамгийн сүүлд буюу 2021 оны 01-р сарын 31-ны өдөр олон салбарыг хамарсан Улсын Онцгой Комисс (УОК), Нийслэлийн Онцгой Комиссын (НОК) Шуурхай штаб, Эрүүл Мэндийн Яам (ЭМЯ), Хөдөлмөр Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, Зам Тээвэр Хөгжлийн Яам (ЗТХЯ), Онцгой байдлын Ерөнхий Газар (ОБЕГ), Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ), Хил Хамгаалах Ерөнхий Газар, Тагнуулын Ерөнхий Газар, Цагдаагийн Ерөнхий Газар, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, Улаанбаатар Төмөр Зам, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) зэрэг 15 байгууллага хамтран үнэлжээ.

ЭМЯ, ДЭМБ, НҮБ-ийн хүүхдийн сангийн техникийн туслалцаатайгаар Вакцины бэлэн байдлын үнэлгээний хэрэгсэл (VIRAT) ба вакцины бэлэн байдлыг үнэлэх хүрээг (VRAF)-ний дагуу КОВИД-19 вакцинжуулалтын үйл ажиллагааны бэлтгэлийг үнэлсэн байна. Эдгээр хэрэгслүүд нь институцийн, үйл ажиллагааны болон санхүүгийн чадавх, дутагдал, хэрэгцээг үнэлэв. Үнэлгээний үр дүнд үндэслэн ихэнх үйл ажиллагаа үргэлжилж байгаа ба үе шатууд бүрэн дуусаагүй байна. Улсын Их Хурал 2020 оны 4-р сарын 29-ний өдөр коронавирусын халдвар /КОВИД-19/ -ыг цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль баталж, баталсан өдрөөс дагаж мөрдөнө гэж тус хуульд заасан ба 2020 оны 12 сарыг 31-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, Улсын онцгой комисс тогтмол хуралдаж, КОВИД-19 халдвар тарахаас урьдчилан сэргийлэх талаар бодлогын шийдвэр гаргасаар байна.

2020 оны 11 сарын 12- ний өдрөөс 12 сарын 1-ны өдөр хүртэл орон даяар Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг буюу хөл хорионы хатуу дэглэмд, 2020 оны 12 сарын 1-ээс 14-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдалд, 2020 оны 12 сарын 13-22-ны хооронд Нийслэлд бэлэн байдлын зэрэг буурч бүх өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн. 2020 оны 12 сарын 23-аас 2021 оны 1 сарын 6-ны өдрийг хүртэл бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн.

КОВИД-19-ийн цар тахлын тархалтын хүрээг хумих зорилгоор авч хэрэгжүүлж буй эдгээр арга хэмжээ нь Монгол Улсын эдийн засаг, нийгэмд сөргөөр нөлөөлж байгаа учраас Монгол улсын засгийн газар тодорхой шийдвэрүүд гаргаж арга хэмжээ авч хэрэгжүүлсээр байна. Тухайлбал 18 нас хүртэлх хүүхдэд сар бүр 100000 төгрөг, 2020 оны сарын 1 хүртэл НДШ төлөөгүй хуулийн этгээдэд татварын алданги, торгуулиас чөлөөлсөн. Төрөөс хэрэгжүүлж буй ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах боломжийг олгосон. Ашигт малтмалын боомтуудыг халдвар хамгааллын журмыг сахиулж бүрэн чадлаар ажиллуулах, эм эмнэлгийн хэрэгслийн гаалийн болон НӨАТ-ийн татвараас чөлөөлсөн. Засгийн газраас цар тахлын үеийн хөл хориотой холбоотойгоор иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлж, цахилгаан, ус, дулааны үнийг 2020 оны 12 сарын 1-ээс 2021 оны 7 сарын 1-ны өдрийг хүртэл тэглэхээр шийдвэр гаргасан. 2020 оны 12 сарын 3-аас шахмал түлшний үнийг 50 хувиар 12 сарын 13-аас 75% болгон бууруулсан. 2021 оны 2 сарын 10 ны өдөр Монгол улсын ерөнхий сайд эдийн засгаа аврахад 2 их наяд төгрөгийг зээлийн хүүг бууруулах, залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд, 3 их наяд төгрөгийг орон сууц барихад, 2 их наяд төгрөгийг дахин санхүүжилтийн төлөвлөгөөнд, хөдөө аж ахуйд 500 тэрбум зарцуулахаар төлөвлөж байгаагаа илтгэсэн.

Монгол Улс ДБ-тай хийсэн зээлийн хэлэлцээрийн үр дүнд 2020 оны 4 дүгээр сард “Монгол Улсад коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл (P173799), 2021 оны 2 сард “Вакцинжуулалтын нэмэлт санхүүжилт” төсөл (P175730)-ийн санхүүжилтийг авахаар ажиллаж байгаа ба энэ төслүүдийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн зорилго нь КОВИД 19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах Монгол улсын чадавхыг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн бэлэн байдлын үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Нэмэлт санхүүжилтийн төслийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд үндсэн төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгэн адил юм. Үүнд: i) вакцин ба эм худалдан авах; ii) вакциныг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд системийг бэхжүүлж, үйлчилгээг сайжруулах; iii) вакцины хэрэглээг хянах, вакцинжуулалтад үзүүлэх сөрөг урвалыг бүртгэх.

Доорх хүснэгтэд төслийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг, үйл ажиллагаанууд болон нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааг харуулав

Хүснэгт 1: Үндсэн үйл ажиллагаа ба Нэмэлт санхүүжилтийн төслийн үйл ажиллагаа

Үндсэн төслийн бүрэлдэхүүн хэсгүүд ба үйл ажиллагаанууд	Нэмэлт санхүүжилтийн дагуу гарсан өөрчлөлтүүд, нэмэлтүүд
Бүрэлдэхүүн хэсэг 1: КОВИД-19-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах	
Дэд хэсэг 1.1. Урьдчилан сэргийлэх гол арга хэмжээг дэмжиж, бүх талын харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа зан үйлийн цогц өөрчлөлтийг (гар угаах, зай барих гэх мэт) дэмжихэд чиглэсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Сонгогдсон зорилтот хүн амыг вакцинжуулах үндэслэлийг олон нийтэд мэдээллээр хангах үйл ажиллагааг бэхжүүлэх;</li> <li>• Вакцины аюулгүй байдал; Вакцинжуулах үйл явц;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Шинэ вакцинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх вакцины бүртгэл ба гаж нөлөө.</li> <li>• Үр дүнтэй харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа нь зорилтот бүлгийн хүн амын дунд КОВИД-19 "вакцины талаар мэдлэг"-ийг нэмэгдүүлж, итгэлцэл бий болгох, гутаан доромжлолыг бууруулах зайлшгүй шаардлагатай болно.</li> </ul>
<p>Дэд хэсэг 1.2. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Бэлтгэл ажлын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Вакцинжуулалт хийх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, ДЭМБ-ын Шударга хуваарилалтын хүрээг үндэслэн вакцин хийлгэх хүн амын тэргүүлэх бүлгийг тодорхойлох;</li> <li>• Вакцинд хамрагдсан иргэдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүнчлэн вакцины сөрөг үр дагаврыг бүртгэх хяналт-шинжилгээ, үнэлгээний (ХШҮ) системийг боловсруулах;</li> <li>• Дүүрэг / аймгууд шинэлэг үйлчилгээ үзүүлэх, олон нийтийн дайчилгааны төлөвлөгөө боловсруулах, нутагшуулах; шаардлагатай тохиолдолд ийм арга хэмжээ авахаар орон нутгийн олон нийтийн байгууллагуудтай гэрээ байгуулах.</li> </ul>
<p>Дэд хэсэг 1.3. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Вакцины хөтөлбөрийг үр дүнтэй байлгах хүний нөөцийн хуваарилалт, сургалтын төлөвлөгөөг багтаасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</li> <li>• Богино хугацаанд улс даяар вакцинаар хангах, халдварын хяналт, эмийн хяналт, байгаль орчны аюулгүй байдлын арга хэмжээ, вакцинаас татгалзаж байгаа иргэдтэй хэрхэн харилцах талаар одоо ажиллаж байгаа болон нэмэлт вакцинжуулагчид (тэтгэвэрт гарсан эрүүл мэндийн ажилтнууд, Улаан загалмайн гишүүд, эм зүйч нар)-ийг бэлтгэх шаардлагатай байна.</li> </ul>
<p>Дэд хэсэг 1.4. Шинэ болон шинээр гарч буй халдварт өвчний эсрэг олон салбарын хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх</p>	<p>Нэмэлт үйл ажиллагаа байхгүй</p>

Бүрэлдэхүүн хэсэг 2: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх	
Дэд хэсэг 2.1. КОВИД-19 оношилгоо, эмчилгээ хийж буй эрүүл мэндийн байгууллагуудыг сайжруулах	Нэмэлт үйл ажиллагаа байхгүй
Дэд хэсэг 2.2. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх хангамжаар хангаж эрүүл мэндийн тогтолцоог дэмжих	<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлагатай агуулах, хүйтэн хэлхээг сайжруулах, вакцинжуулахад шаардлагатай вакцин, хангамжийг худалдан авах үйл ажиллагааг бэхжүүлэх,</li> <li>• Ус хангамж ариун цэврийн байгууламж барих болон байгаль орчны эрүүл мэндэд чиглэсэн иргэдийн санаачилгуудыг дэмжиж болно.</li> </ul>
Бүрэлдэхүүн хэсэг 3: Хэрэгжилтийн удирдлага ба хяналт-шинжилгээ, үнэлгээ	
Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь НТХН-ийн ажилтнууд болон хяналт, үнэлгээг дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Вакцин худалдан авах, хүйтэн хэлхээг бэхжүүлэх, вакцинжуулалт хийхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр удирдлага, хяналт тавихад шаардагдах нэмэлт техникийн ажилтнуудыг дэмжих, Үүнд: түнш байгууллагууд, ялангуяа НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-ын олон талт үүрэг оролцоог хангах болно. Дархлаажуулалтын ердийн бүртгэлээс гадна хүн бүрт олгосон вакцины Баар кодыг баримтжуулсан өдөр тутмын бүртгэл, вакцинжуулалтын сөрөг үр дагаврын бүртгэлийг хөтөлнө.</li> </ul>
Бүрэлдэхүүн 4: Гэнэтийн болзошгүй үед үзүүлэх хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг	
Хүлээн зөвшөөрөгдөх хямрал, онцгой байдлын үед төсөл нь цаг алдалгүй үр дүнтэй хариу үзүүлэхэд хувь нэмэр оруулах болно.	Нэмэлт үйл ажиллагаа байхгүй

### Үндэслэл

Монгол Улс Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хамгааллын талаарх бодлогын баримт бичиг, дүрэм журам, шаардлагад нийцүүлэн эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн. Төслийн үйл ажиллагаа болон аливаа дэд төсөл, түүний үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлох, хүрээлэн

буй орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, зохицуулахад чиглэсэн удирдамжуудаар төсөл хэрэгжүүлэгч талуудыг хангах зорилготой Дэлхийн банкны Байгаль орчин нийгмийн удирдлагын хүрээ (БНУХ)-ний хэрэгжилтийг хангах “Байгаль орчин, нийгмийн стандарт-10” (БОНС10) буюу “Талуудын оролцоог хангах, мэдээлэл ил тод болгох” журмын дагуу “Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл” болон “Вакцинжуулалтын нэмэлт санхүүжилт” төслүүд “Талуудын оролцоог хангах” төлөвлөгөөг боловсруулав.

## 2. Оролцогч талуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх

Оролцогч талуудтай ил тод нээлттэй, хүртээмжтэй, уян хатан, эргэх холбоотой харилцах зарчмыг баримтлан төсөл оролцогч талуудтай зохистой, заль мэх хэрэглэхгүй, хөндлөнгийн оролцоо, албадлагагүй ялгаварлан гадуурхахгүй, айлган сүрдүүлэхгүй харилцаж төслийн оролцогч бүх талуудад цаг тухайд нь, хамааралтай, ойлгомжтой, тодорхой мэдээллээр ханган эргэх холбоо бий болгох зорилготой бөгөөд Үндсэн төсөл ба Нэмэлт санхүүжилт (цаашид Төсөл) –ийн төслийг хамарч байна.

Төслийн Талуудын оролцоог хангах төлөвлөгөөг боловсруулахдаа энэ чиглэлээр баримталж буй үндэсний бодлогын баримт бичиг төлөвлөгөө, бусад ОУ-ын түнш байгууллагын дүрэм журамд нийцүүлэн боловсруулах бодлого баримталсан болно. ТОХТ нь төслийн баг оролцогч талуудтай хэрхэн харилцах арга замыг тодорхойлж оролцогч талууд төсөл болон төсөлтэй холбоотой аливаа үйл ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлэх, санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизмыг багтаасан болно. Үүнд:

- Төрийн байгууллагууд, нийгмийн эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын хөгжлийн түншүүд, үндэсний төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн түншүүд, нийт хүн ам, олон нийтэд төслийн талаар тасралтгүй мэдээллээр хангах,
- Төслийг хэрэгжүүлэхээс өмнө болон хэрэгжүүлэх явцад цаг тухайд нь, зохих мэдээллээр оролцогч талуудыг хангаж, зохих нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох боломжийг олгох,
- Нөлөөлөлд байгаа бүх бүлгүүдийн тэгш оролцоог дэмжих,
- Төслийн үйл ажиллагаа, арга хэмжээний байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах:
  - Төслийн ажилчдын үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй (ХАБЭА);
  - Эрүүл мэндийн ажилчдын дунд вирусийн тархалттай холбоотой ХАБЭА-н эрсдэл;
  - Хүн амын дунд КОВИД-19-ийн тархалттай холбоотой КОВИД 19-ийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авахтай холбоотой сургалт, харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа, олон нийтийн мэдлэг, мэдээлэл муу байгаагаас ялангуяа хамгийн эмзэг, эмзэг бүлгийн хүмүүс эрсдэлд өртөх (өндөр настан, өндөр эрсдэлтэй хүүхдүүд - хоол тэжээлийн дутагдалтай, ядуу өрх гэх мэт),
  - Хуурамч цуурхал, нийгмийн эмх замбараагүй байдал, КОВИД-19-тэй холбоотой нийгмийн гутаан доромжлол, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой туршигдсан болон бусад үйлчилгээнд холбогдох эмх замбараагүй байдал, түүний дотор үйлчилгээ авах боломжгүй болсон зэрэг эмх замбараагүй байдал / зөрчилдөөн үүсэх эрсдэл.



- Аливаа нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын саналыг авах,
- Төслийн оролцогч талууд болон олон нийт нээлттэй, тасралтгүй харилцаа холбоотой, зөвлөлдөх боломжийг бүрдүүлэх,
- Оролцогч талуудын тавьсан санал хүсэлтэд хариу өгөх, үүнтэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх,
- Төсөлтэй холбоотой аливаа гомдлыг шийдвэрлэх зорилго бүхий өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизмыг (ӨГШМ) бий болгох, хэрэгжүүлэх

## 2.1 Арга зүй, зарчим

Талуудын оролцоог хангах тус төлөвлөгөөг бодит, үр дүнтэй, монгол ахуй соёлд нийцүүлэн дараах зарчмуудыг баримтлан төсөл хэрэгжүүлэх хугацаанд хэрэгжүүлнэ. Үүнд:

- **Ил тод, нээлттэй байдал:** төслийн мэдээллийг зохих хэлбэрээр бүх оролцогч талуудад ил тод, нээлттэй, тогтмол түгээж байхын зэрэгцээ, олон нийтийн хэлэлцүүлэг, ярилцлагыг гадны нөлөөнөөс ангид, хөндлөнгийн оролцоо, албадлага, сүрдүүлэггүйгээр бүх насны ангилал, онцлогт тохируулан зохион байгуулна.
  - **Хүртээмжтэй, уян хатан байдал:** Бүх оролцогч талуудад мэдээллийг тэгш, хүртээмжтэй хүргэж, оролцоог тэгш хүртээмжтэй байлгахад чиглэж, төслийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж ажиллана. Эмзэг бүлгийнхэн, ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, шилжин суурьшсан иргэд, эрүүл мэндийн асуудалтай хүмүүс, үндэстний цөөнх иргэд, алслагдсан хязгаар нутгийн иргэдэд онцгой анхаарал хандуулна. Оролцогч бүх талуудын хэрэгцээг байнга харгалзан авч үзэж, тухайн нөхцөлд байдалд мэдрэмжтэй хариу үйлдэл үзүүлж үйл ажиллагааны уян хатан байдлыг эрхэмлэж ажиллана.
- Эргэх холбоог бий болгож, үр дүнтэй тайлагнах:** Оролцогч талуудын санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх, тайлагнах тодорхой арга замуудыг хангаж ажиллана.

## Оролцогч талууд

Оролцогч талууд гэж тус төслийн үйл ажиллагаа өөрт нь нөлөөлж байгаа, төслийн үйл ажиллагаанд өртөж байгаа хувь хүн, бүлгүүд, хуулийн этгээдийг хэлнэ. Үр дүнтэй, зохих оролцоог хангах зорилгоор төслийн оролцогч талуудыг дараах үндсэн ангилалд хувааж авч үзэж байна. Үүнд:

## 2.2 Нөлөөлөлд өртсөн талууд

Төслийн шууд нөлөөлөлд өртсөн (бодитой эсхүл болзошгүй) Төслийн Нөлөөллийн Бүс (ТНБ) -т багтсан ба / эсхүл төсөлтэй холбоотой өөрчлөлтөд хамгийн өртөмтгий гэж тодорхойлогдсон хүмүүс, бүлгүүд болон бусад байгууллагууд багтана.

Төслийн Оролцогч талуудыг дараах байдлаар засаг захиргааны шатлалаар нарийвчлан тодорхойлов.

### 1. Төрийн байгууллага:

#### а) Үндэсний түвшинд

- Улсын онцгой комисс,
- ЭМЯ
- ЭМЯ-ны вакциныг байрлуулах төлөвлөгөөний ажлын хэсэг

- Дархлаажуулалтын үндэсний хороод (Дархлаажуулалтын зөвлөх хороо, Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох хороо)
- Онцгой байдлын ерөнхий газар
- Тагнуулын төв газар
- Халдварт өвчин судлалын үндэсний төв буюу эмнэлэг, тусгаарлах байр халдвар авсан хүмүүсийг сувилж, эмчилж буй эрүүл мэндийн ажилтнууд
- Улсын нэгдсэн төв эмнэлгүүд болон нийслэл, аймаг сум дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, хувийн хэвшлийн эмнэлгүүд
- МХЕГ
- Лабораториуд
- Ариутгал халдваргүйтгэлийн төвүүд
- Дайчлан ажиллуулах, Анагаахын сургуулийн багш, оюутан
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- Эрүүл мэндийн хөгжлийн төв
- Хил гааль, цагдаа хүчний байгууллага, тусгай албад эдгээртэй холбоотой сургууль, сургалтын байгууллага мөн ШӨХТ байгууллага, нийтийн тээвэр, төмөр зам, тээвэр зууч, нисэх байгууллага зэрэг

*b) Аймаг нийслэл, сум дүүргийн түвшинд*

- Аймаг нийслэл, сум дүүргийн онцгой комисс
- Эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв, сум дүүргийн эмнэлэг
- Эрчим хүч, ус дулаан хангамж, ариутгал, хот тохижилт үйлчилгээний байгууллага,

*c) Баг/ өрхийн түвшинд*

- өрхийн эрүүл мэндийн төвийн бүх ажилтан
- баг хорооны дарга, хэсгийн ахлагч
- СӨХ, Орон сууцны засвар үйлчилгээний компани

2. Олон нийт:

- КОВИД19 халдвар авсан хүмүүс
- КОВИД 19 халдвар авсан хүмүүсийн гэр бүл төрөл төрөгсөд
- Батлагдсан тохиолдлуудын эхний болон хоёрдогч хавьтагчид
- Лаборатори, тусгаарлах байр, үзлэгийн постны зэргэлдээх оршин суугчид
- Халдварт өвчин судлалын үндэсний төв эсхүл эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүд
- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа болон шинжилгээ өгч буй үйлчлүүлэгчид, түр хугацаагаар эмчлүүлэгчид
- КОВИД 19 хорио цээрийн дэглэмд байгаа хүмүүс, тусгаарлах байрны ажилчид
- КОВИД 19-ийн эрсдэлд буй хүмүүс тухайлбал тохиолдлууд тогтоогдсон газрын оршин суугчид, Хил орчмын хотуудад эсхүл түүний ойролцоо оршин суугчид.
- Агаарын тээврийн компаниуд болон бусад олон улсын тээврийн логистикийн бизнес
- Нийтийн тээврийн хэрэгсэл, зам, хот хоорондын нийтийн тээврийн жолоочид, таксины жолооч

- Хүргэлтийн үйлчилгээ эрхлэгчид
- Дуудлагын үйлчилгээ үзүүлэгчид
- Сургууль, эмнэлэг, дэлгүүр, ресторан, паб, сургалтын төв, спорт, фитнес төв, үсчин гэх мэт олон нийтийн газруудын ажилчид, үйлчлүүлэгчид, худалдагч, аялагчид ... гэх мэт.
- Хот тохижилт, цэвэрлэгээ, ариутгах татуургын ажилчид
- Ус сувгийн удирдах газрын ажилчид,
- Эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгал, хог хаягдал, нийтийн аж ахуй , инженер хангамжийн байгууллагын ажилчид
- Банк, хэвлэл мэдээллийн ажилчид
- Хүүхэд хамгаалал, ахмадын асрамжийн газрууд
- Газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн газрууд
- Сайжруулсан түлшний, үйлдвэрлэл нийлүүлэлт, түгээлтийн цэгүүд
- Вакцинжуулалт, КОВИД -19 эмчилгээний үйл ажиллагаанд хамрагдах сайн дурын ажилтнууд
- Төслийн дэмжлэгтэй холбоотой үйл ажиллагаанд өртсөн эсхүл бусад хэлбэрээр хамрагдсан хүмүүс

### 2.3 Бусад сонирхогч талууд

Төслийн шууд нөлөөлөлд өртөөгүй, гэхдээ өөрсдийн ашиг сонирхлыг төслийн нөлөөлөлд өртсөн гэж үзэж буй эсхүл тэгж ойлгодог, төсөл, түүний хэрэгжилтийн явцад ямар нэгэн байдлаар нөлөөлж болзошгүй хувь хүмүүс / бүлгүүд / байгууллагууд багтана.

- Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд зэрэг бүх шатны төрийн шийдвэр гаргагчид
- Монгол дахь хандивлагчид, олон улсын байгууллагууд, элчин сайдын яамд
- Гадаадад суугаа Монголын консул, элчин сайдын яамд
- Үндэсний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчид
- Олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн улс төр,нийгэм соёлын зүтгэлтнүүд,манлайлагч, алдартнууд, нөлөө бүхий хүмүүс, соён гэгээрүүлэгчид, ялангуяа нийгмийн сүлжээний (Фэйсбүүк, твитер) гол нөлөөлөгчид гэх мэт
- Тохиолдол батлагдсан гадаад оронд ажиллаж, амьдарч буй монгол иргэн
- Бусад үндэсний ба олон улсын төрийн бус байгууллагууд
- Хувийн хэвшил-Дотоодын болон олон улсын бизнесүүд
- Олон нийт

### 2.4 Эмзэг бүлэг

Эмзэг байдлаасаа болоод бусад бүлгүүдтэй харьцуулахад төсөл (үүд) жигд бусаар нөлөөлж болзошгүй эсхүл хохирч болзошгүй хүмүүс бөгөөд энэ нь төсөлтэй холбоотой зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл явцад тэдний тэгш төлөөллийг хангахын тулд тусгай оролцоо, хүчин чармайлт шаардагдана. Төслийн хүрээнд хязгаарлагдмал болон онцгой нөхцөлд байгаа эмзэг бүлгийнхэнд дараах хүмүүс багтаж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

- Гэртээ эсхүл асрамжийн газарт байдаг өндөр настнууд;
- Архаг, хууч өвчтэй өвчтөн (АЗӨ, ЗСӨ, чихрийн шижин болон бусад)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эсхүл асрамжийн газар
- Түр хугацаагаар тусгаарласан эсхүл тусгаарлалтад байгаа хүмүүс
- Алслагдсан болон хязгаар нутагт (Дэд бүтэц байхгүй) амьдардаг иргэд, хүүхдүүд
- Үндэстний цөөнх / казах, духа буюу цаатан /
- Өрх толгойлсон ганц бие эцэг, эх
- Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой хүн ам
- Эх орондоо буцаж ирсэн хүмүүс
- Эрүүл мэндийн шалтгаанаас группэд орсон
- Хүүхдийн асрамжийн газар
- Орон гэргүй тэнэмэл амьдралтай хүмүүс
- Хязгаар нутагт байгаа улс хоорондын тээврийн жолооч
- Хаягийн бүртгэлгүй (задгай гэсэн хаягтай) гэр хороололд амьдардаг өрхүүд

### 3.Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)

#### 3.1 Төсөл боловсруулах явцад талуудын оролцоог хангасан байдал-тойм

Засгийн газар, Улсын Онцгой Комисс 3-р сарын 30-ны өдрийг хүртэл олон нийтийн цугларалтыг хорьсонтой зэрэгцэн КОВИД-19 цар тахлын аюулыг даван туулах зорилгоор Үндсэн төслийг яаралтай боловсруулсан. Төслийн ТОХТ –ний төсөл Дэлхийн Банкаар батлагдаж зөвшөөрөгдөхөөс өмнө боловсруулсан байх ёстой бөгөөд тухайн үеийн үүссэн нөхцөл байдлын улмаас бүрэн хэмжээнд тус төлөвлөгөөг боловсруулж бэлэн болгох боломж хязгаарлагдмал байв.

Тиймээс үндсэн төслийн анхны ТОХТ-г төслийг оролцогч талуудын оролцооны стратеги, цаашдын нарийвчилсан төлөвлөгөөний үйл явцын эхлэл болгож төслийг үнэлэхээс өмнө боловсруулж, олон нийтэд түгээж ил болгосон.

Тус төлөвлөгөөний дагуу үндсэн төслийн 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд эрсдлийн харилцаа/олон нийттэй харилцахад чиглэсэн 17 үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд (а) олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан өвчнөөс урьдчилан сэргийлэх, удирдан зохион байгуулах нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны кампанит ажил; (б) халдварын хяналтын удирдамж, үйлчилгээний стандартыг бий болгох; (в) яаралтай тусламжийн эмч, сувилагч, тархвар судлаач, эмнэлгийн ажилчдыг багтаасан тэргүүн эгнээний үндсэн ажилтнуудыг сургах зэрэгт чиглэсэн үйл ажиллагаанууд багтаж байна.

Эрүүл мэндийн яам дээрх үйл ажиллагааны хүрээнд 533 инфографик, 271 төрлийн мэргэжлийн эмчийн зөвлөмж бүхий видео материал боловсруулж фэйсбүүк хуудсаар дамжуулан хүргэж, давхардсан тоогоор 44 сая орчим хүнд хүрчээ. Бүх гар утас хэрэглэгчдэд өдөрт нэг удаа КОВИД-19-ээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, зөвлөгөө хүргэж байна. ЭМЯ бусад холбогдох байгууллага, гол оролцогч талуудтай хамтран 2021 оны 02 сарын 09 байдлаа өдөр бүр өдөрт 1-2 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж КОВИД-19-ийн цаг үеийн байдлын талаар мэдээлэл, зөвлөмж өгч байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас КОВИД-19-той холбоотой мэдээлэл, судалгааны ажлын үр дүнг түгээх, үзэгчид болон оролцогч талуудаас санал хүсэлт, гомдлыг барагдуулах зорилгоор тусгай зориулалтын платформ, сувгуудыг нээж ажиллуулж байна.

Нэмэлт санхүүжилтийн төслийн хувьд вакцин, эм худалдан авах, вакцины үр дүнтэй байдлыг хангахын тулд системийг бэхжүүлэх, үйлчилгээ үзүүлэх хүчин чармайлтыг дэмжихээр төлөвлөж байгаа тул үр дүнтэй харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа нь оролцогч талуудад КОВИД-19 вакцины талаар мэдээлэл түгээх, мэдлэг нэмэгдүүлэх, итгэлцлийг бий болгох, буруу хандлагыг бууруулах зайлшгүй шаардлагатай юм.

Засгийн газар 2020 оны 10-р сарын 28-ны өдөр гаргасан олон нийтээр цугларахыг хязгаарлах тухай шийдвэрийн хугацааг сунгаж, мөн Гамшгийн тухай хуульд заасны дагуу 2020 оны 11-р сарын 23-наас 12 дугаар сарын 1 хүртэл улс даяар бүх нийтийн бэлэн байдлын дэглэмийн зэрэгт шилжин үргэлжлүүлэн тус дэглэмийг 12-р сарын 23-ныг хүртэл сунгах шийдвэр гаргасантай холбогдуулан тус төслийн санхүүжилтийг батлагдахын өмнө боловсруулах ёстой ТОХТ-г боловсруулах зөвлөлдөх уулзалтуудыг хийх боломж хязгаарлагдмал байв.

Вакциныг тараах, вакцинжуулах журам зэргийг багтаасан КОВИД-19-ын вакцинжуулалтын үндэсний төлөвлөгөөг Улсын Онцгой комиссын 2021 оны 1-р сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор баталсан. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай 2021 оны 2-р сарын 2 -ны өдрийн Эрүүл мэндийн сайдын 33 тоот тушаал гарсан.

КОВИД-19 вакцинжуулалтын хөтөлбөрийн хувьд талуудын оролцоо нь вакцины хуваарилалтыг эрэмбэлэх зарчим, вакциныг хуваарилах, вакцинд хамрагдалтын хувиар, эмзэг бүлэгт хүрч үйлчлэх, эрэлт хэрэгцээтэй тулгардаг саад бэрхшээлийг даван туулах (вакцинд үл итгэх, гутаан доромжлох, соёлын эргэлзээ гэх мэт) буруу хуваарилалт, ялгаварлан гадуурхалт, авилгын эсрэг хариуцлагыг бий болгоход чиглэгдсэн болно.

Үүний зэрэгцээ ДЭМБ вакциныг түгээх төлөвлөгөө боловсруулж байна. НҮБ-ын Хүүхдийн сан вакцинжуулалттай холбоотой техникийн баримт бичиг тухайлбал олон нийттэй хэрхэн харилцах удирдамж зэргээр ханган ажиллаж байна.

### 3.2 Талуудын оролцоог хангах арга хэрэгсэл

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль / Ковид-19, түүний нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, ДЭМБ-ын “КОВИД-19 Стратегийн бэлтгэл, хариу арга хэмжээний төлөвлөгөө - Улс орны бэлэн байдал, хариу арга хэмжээг дэмжих үйл ажиллагааны төлөвлөлтийн удирдамж” (2020) нь төслийн талуудын оролцоог хангахад ашиглах үндсэн хэрэгсэл байх болно.

Улсын хэмжээнд олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалт, семинарыг зохион байгуулахыг хориглож байгаа учраас оролцогч талуудын оролцоог хангах мэдээлэх, зөвлөлдөх, санал авах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хууль дүрэм журамд заасны дагуу дараах арга хэрэгслийг ашиглаж зохион байгуулах боломжтой байна.

#### **КОВИД-19-ийн үеэр оролцоог хангах арга хэрэгслүүдийг ашиглах үндсэн зарчим**

- Шинэ хуулийн дагуу холбогдох байгууллагаас гаргасан шийдвэр, арга хэмжээ, төслийн талаар болон төсөлтэй холбоотой үйл ажиллагааны талаарх мэдээллийг

талуудад цаг тухайд нь хүртээмжтэй түгээх, тэдэнтэй санал солилцох, тэднийг санал хүсэлт хүлээж авах, хариу мэдэгдэх зорилгоор оролцогч тал бүрт тохирсон олон төрлийн харилцаа холбоо, хамтын ажиллагааны суваг, тусгай платформыг тодорхойлж хэрэгжүүлэх,

- Олон нийтийн цугларалтаас зайлсхийж, нөлөөлөлд өртсөн хүмүүсийн шууд харилцааг багасгах цахим хэлэлцүүлэг, семинар, бүх нийтийн уулзалт зохион байгуулах арга хэрэгсэл, сувгийг тодорхойлж ил тод болгох
- Цөөн оролцогчидтой уулзалтыг зөвшөөрсөн / зөвлөсөн бол фокус бүлгийн уулзалт гэх мэт жижиг бүлгийн уулзалтуудаар зөвлөлдөнө. Зөвшөөрөгдөөгүй эсхүл зөвлөөгүй бол цахим сувгаар зохион байгуулах
- Биечилсэн уулзалт хийхийг хориглосон тохиолдолд мэдээлэл харилцааны суваг, арга хэрэгслийг төрөлжүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, онлайн сувгууд, нийгмийн сүлжээг түлхүү ашиглах
- Оролцогч талуудын төрөл, ангилалд үндэслэн тусгай зориулалтын онлайн платформ, чат бүлэг үүсгэх;
- Төсөлд өртсөн хүмүүс эсхүл ашиг хүртэгчидтэй шууд харьцах шаардлагатай, хойшлуулах боломжгүй тохиолдолд нөлөөлөлд өртсөн өрх бүртэй шууд холбоо барих сувгийг тодорхой болгоно. (Цахим шуудан-и мэйл, утсаар, цахимаар ярилцах, гар утасны мессеж, нийгмийн сүлжээний мессеж, тусгай дугаар бүхий утасны шугам зэрэг)
- Оролцогч талууд онлайн сувгуудад нэвтрэх боломжгүй эсхүл байнга ашигладаггүй тохиолдолд мэдээллийг хүртээмжтэй шуурхай хүргэх хэвлэл мэдээллийн уламжлалт суваг-ТВ, сонин, радиогийн сувгуудыг тодорхойлж, мэдээлэл түгээх.
- Оролцогч талуудын хооронд харилцаа болон оролцооны суваг бүрээр хэрхэн санал хүсэлт, хариу үйлдэл гаргаж болохыг тодорхой зааж өгөх,
- Мэдээлэл түгээх, оролцогч талуудын оролцоонд зуучлагч болж чадахуйц итгэмжлэгдсэн төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага, олон нийт хувь хүн болон түүнтэй ижил төстэй оролцогчдыг тодорхойлж, тэдэнтэй байнгын холбоотой ажиллах.
- Оролцогч талууд тус бүртэй зөвлөлдөхдөө дараах аргуудыг ашиглах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй зорилтот бүлгээс хамаарч өөр байж болно.
  - Оролцогч талууд болон холбогдох байгууллагатай ярилцлага хийх
  - Тодорхой сэдвээр олон нийтийн уулзалт, семинар, эсхүл фокус бүлгийн ярилцлага
  - Биеэр уулзах
  - Судалгаа, санал асуулга, асуумж
  - Бусад уламжлалт механизмууд, тухайлбал баг, хорооны хурлаар дамжуулан зөвлөлдөх, шийдвэр гаргах.
  - Цахим хуудас болон фэйсбоок, вайберь, телеграм, чатаар харилцах
  - Утасаар ярих, и-мэйлээр харилцах

### 3.3 Оролцогч талуудад мэдээлэл түгээх стратеги

Халдварт өвчин, цар тахал түүний эрсдэл, эдгээртэй холбоотой бүхий л асуудлаар өргөн хүрээг хамарсан, ард түмний соёл заншилд нийцсэн мэдлэг дээшлүүлэх, мэдээлэл түгээх, мэдээлэл солилцох, харилцах тохирсон сувгийг тодорхойлж, ашиглахад онцгой анхаарна.

Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд мэдээлэл түгээдэг уламжлалт сувгууд болох хэвлэл мэдээллийн хэрэгсэл телевиз, сонин, радио, хэвлэмэл материал, зурагт хуудас,

тусгай утас, гар утасны мессеж, самбар үзүүлэн, зарлан мэдээлэх, зэрэг уламжлалт харилцаа холбооны сувгуудыг ашиглана.

Түүнчлэн олон нийтийн дунд хэрэглээ нь өсөн нэмэгдэж хурдацтай хөгжиж байгаа мэдээлэл түгээх, солилцох цахим бүх төрлийн сувгуудыг ашиглаж мэдээлэл түгээнэ. Фэйсбоок, твитер, инстаграм зэрэг хүмүүсийн өргөн хэрэглэдэг нийгмийн цахим сүлжээг ашиглана.

Төсөл талуудын оролцоог хангаж мэдээлэл түгээх зорилгоор Цахим эрүүл мэнд төслийн цахим хуудсыг өргөжүүлэн Нэгдсэн төсөлд хэрэглэж байна. Тус цахим хуудсанд төслийн баримт бичгүүд, төслийн удирдах хороо болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүрэлдэхүүний талаар мэдээлэл, засгийн газрын шилэн данс, төсөл хэрэгжүүлэх нэгжийн байршил болон санал хүлээж авах хэсгүүд багтана.

Төсөл нь фэйсбүүк хуудсыг нээж, цар тахлын болон коронавирусын халдвар, төслийн хэрэгжилттэй холбоотой хамгийн сүүлийн үеийн мэдээ, зөвлөмж, ололт, байнга асуудаг асуултуудыг дамжуулж, харилцагчид шаардлагатай мэдээллээ чатботоор авах боломжийг олгож байна.

Хүнсний зах, дэлгүүр, банк, эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төв, гудамж, талбайн, орон сууцны самбар зэрэг олон нийтийн зорчдог гол байршил болон хот хоорондын болон хот доторх нийтийн тээврийн хэрэгсэлд мэдээлэл, сурталчилгаа зөвлөгөөг байршуулж, зарлан мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хэвлэл мэдээллийн байгууллага, холбогдох олон нийтийн байгууллага, хувь хүн соён гэгээрүүлэгч, нийгмийн манлайлагч нартай хамтран ажиллах замаар олон нийтэд мэдээлэл түгээнэ.

Коронавирусын дэгдэлтийн үед аяллын хориг, хөл хорио зэргээс шалтгаалан хаалганаас хаалганд хүрч ярилцлага хийх боломжгүй, болзошгүй эрсдэлээс үүдэн мэдээллийн технологид суурилсан механизмуудаар дамжуулан төслийн оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна.

Вакцинжуулалттай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийн хүрээнд хүн амд болон эмзэг бүлэгт вакцины мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөнд тусгагдсан олон арга барилыг ашиглана. Зарим гол тэргүүлэх чиглэлүүдэд ашиг хүртэгчдэд болон вакцин авахад тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаар онлайн зөвлөгөөн явуулах; өвчний талаарх буруу ойлголт, вакцины танилцуулга, аливаа сөрөг ойлголтыг эсэргүүцэх, КОВИД-19 вакцины хөтөлбөрийн талаар болон эрсдэл өндөртэй бүлгийнхэн, дагалдах хэрэгслийн хүртээмж, хоёр дахь тунгаа хийлгэх хүмүүсийг хянах зэрэгт болгоомжтой хандана.

НТХН нь томоохон уулзалт, семинар зайлшгүй шаардлагатай нөхцөлд виртуал семинар зохион байгуулах зорилгоор веб семинар, Skype, Zoom зэрэг онлайн холбооны сувгуудыг ашиглах болно. Гэхдээ мэдээллийн технологийн багтаамж багатай нөхцөлд аудио уулзалтууд нь виртуал семинар зохион байгуулж болно. Цахимаар харилцахад бэрхшээлтэй байгаа тохиолдолд мэдээллийг Facebook, chat-bot, Twitter, WhatsApp, төслийн цахим хуудас, ЭМЯ-ны цахим хуудас, харилцаа холбооны уламжлалт хэрэгсэл ТВ, сонин, радио, утасны дуудлага, дижитал платформ (боломжтой бол) шуудангаар болон / эсхүл тусгай зориулалтын утасны шугамаар дамжуулан хариу өгөх механизмаар дамжуулж болно.

ЭМЯ нь гар утасны мессежийг ашиглан мэдээллийг хүргэх хамгийн хялбар бөгөөд хурдан шуурхай үйлчилгээг үзүүлж байна. Судалгаа хийх, мэдээлэл цуглуулахад чухал ач

холбогдолтой зөвшилцлүүдийг Google форум зэрэг үнэгүй санал асуулга авах технологийг ашиглах, survey monkey, дижитал платформд нэвтрэх эрхгүй хүмүүст GeoPoll зэрэг гар утасны мессежинд тулгуурласан асуулгын платформыг ашиглана. НТХН нь олон нийтийн түвшний мэдээллийг цуглуулахын тулд өдөрт хэдэн мянган хариулт авч ашиглах боломжтой юм.

Үндэстний цөөнх, нийгмийн эмзэг бүлэг, алслагдсан бүс нутгийн иргэдийг тасралтгүй, тогтмол мэдээлэл хүлээж авах боломжоор хангахын тулд дараах арга хэмжээ, сувгуудыг ашиглана.

Тухайлбал үндэстний цөөнхийн хэлээр мэдээ, нэвтрүүлэг бэлтгэж улс орон даяар цацдаг Монголын Үндэсний Олон нийтийн Радио, Телевизийн тухайлсан нэвтрүүлгээр мэдээлэл түгээнэ. Мэдээлэл, зөвлөмжийг цөөнх үндэстний хэлээр хэвлэж түгээнэ. Мөн тэдгээр хүмүүстэй харилцахдаа, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, сум, хорооны нийгмийн ажилтнаар дамжуулна.

Төсөл нь мэдээлэл, эмнэлгийн байгууллага, үйлчилгээнд хамрагдах, гэртээ, ажлын байр, орон нутагтаа тулгарч буй бусад бэрхшээл, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг ойлгохын тулд эмзэг бүлгийн хүмүүстэй зорилтот талуудын оролцоог хэрэгжүүлж ажиллана. Эмэгтэйчүүдэд онцгой анхаарал хандуулах болно. Эмзэг бүлгийнхнийг оролцуулах, тэдэнтэй харилцах зорилгоор батлах стратегийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг төсөл хэрэгжүүлэх явцад анхаарна. Үүнд

(i) Эмэгтэйчүүд: Олон нийтийн оролцооны багууд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж, эдгээрийн хүрээнд эмэгтэйчүүдийн манлайллыг сурталчлах, онлайн болон биечлэн судалгаа хийх, бусад оролцооны үйл ажиллагааг зохион байгуулах, ингэснээр цалингүй хүн асардаг эмэгтэйчүүд оролцох боломжтой байх; биечлэн оролцож буй аливаа үйл ажиллагаанд хүүхэд асрах, унаа тээвэр, аюулгүй байдлыг хангах асуудлыг авч үзнэ; (ii) Жирэмсэн эмэгтэйчүүд: Жирэмсэн эмэгтэйчүүдэд эрүүл ахуйн анхан шатны хэрэглээ, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тэдний асуусан асуудлын дагуу хэрхэн, хаанаас тусламж авах тухай мэдлэг олгох материалыг боловсруулах; (iii) Ахмад настан, эрүүл мэндийн асуудалтай хүмүүс: яагаад илүү их эрсдэлд орохоор байгааг тайлбарлаж, тэдэнд анхаарал хандуулахын тулд ямар арга хэмжээ авах талаар, тусгай хэрэгцээний талаарх мэдээллийг боловсруулах; амьдралын нөхцөл (үүнд туслах байгууламжууд орно)-ийн талаар, эрүүл мэндийн байдал зэрэгт нь тохирох мессеж боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх боломжтой болгох; зорилтот гэр бүлийн гишүүд, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч, асран хамгаалагчид; (iv) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: хүртээмжтэй хэлбэрээр брайль, том хэвлэмэл хэлбэрээр мэдээллээр хангах; дохионы хэлмэрч бүхий видео бичлэг, сонсголын бэрхшээлтэй хүмүүст текст тайлбар, туслах технологийг ашигладаг хүмүүст зориулсан онлайн материал гэх мэт олон арга замуудыг санал болгох; ба (v) Хүүхдүүд: мэдээлэл, харилцаа холбооны материалыг хүүхдэд ээлтэй байдлаар боловсруулж, эцэг эхчүүдэд сэтгэлийн зовнилоо зохицуулж, хүүхдүүдийнхээ менежментэд туслах чадварыг эзэмшүүлнэ.

Дээрх хэлбэрээр оролцогч талуудын хэрэгцээнд тулгуурласан тэдний ашиглахад хялбар дөхөм шаардлагатай бүх мэдээллийн сувгийг ашиглах болно.



**Хүснэгт 2: Мэдээлэл ил тод болгох, түгээх арга хэрэгсэл/суваг**

Төслийн үе шат	Зорилтот талууд	Түгээх мэдээллийн жагсаалт	Түгээх арга зүй/хэрэгсэл суваг
1-р хэсэг	Бүх талууд	<p>КАР судалгааны тайлан</p> <p>Талуудын оролцоог хангах төлөвлөгөөг ил тод болгох,</p>	<p>Мэдээлэл түгээх арга хэрэгсэлд заасан бүх суваг, арга хэрэгсэлийг ашиглана.</p> <p>ЭМЯ, КОВИД-19 төслийн цахим сайтуудууд байрлуулж санал авна.</p> <p>(Судалгааны тайланг эцэслэсний дараа Төслийн цахим хуудаснуудад байршуулна)</p>
Төслийн туршид	Бүх талууд	<ul style="list-style-type: none"> <li>- Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн тайлан</li> <li>- Төслийн хэрэгжилтийн жилийн тайлан,</li> <li>- ӨГШМ-ийн хагас жилийн тайлан</li> </ul> <p>-Мэдээлэл сурталчилгааны материал, зөвлөмж , судалгааны тайлан</p>	<p>Мэдээлэл түгээх арга хэрэгсэлд заасан бүх суваг, арга хэрэгсэлийг ашиглана.</p> <p>ЭМЯ, КОВИД-19 төслийн цахим сайтууд, фэйсбүүк хуудсаар хуваалцах</p> <p>Шаардлагатай бол хэвлэлийн бага хурал</p>
	Эмзэг бүлэг, цөөнхийн бүлэг	<p>Талуудын оролцоог хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн тайлан</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн хэрэгжилтийн жилийн тайлан,</li> <li>- ӨГШМ-ийн хагас жилийн тайлан</li> </ul> <p>-Мэдээлэл сурталчилгааны материал, зөвлөмж , судалгааны тайлан</p>	<p>- Мэдээлэл түгээх арга хэрэгсэл болон эмзэг бүлгийн оролцоог хангах арга хэрэгсэл –тус баримт бичгийн 4.1 т заасны дагуу эмзэг бүлэг бүрт тохирох арга хэрэгсэлийг ашиглана.</p> <p>Тодруулбал: Үндэстний цөөнх казах хэлээр материал боловсруулж бэлтгэх, цөөнхийн хэлээр нэвтрүүлэг бэлтгэдэг орон нутгийн болон үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэл түгээх, шаардлагатай бүх мэдээллүүдийг дохионы хэлтэй түгээж , брайль үсгээр хэвлэх, алслагдсан дэд бүтэц сул иргэдэд багийн даргаар дамжуулж хэвлэмэл материал түгээх гэх мэт...</p>
	Бүх талууд	<p>Төслийн удирдамж, зөвлөмж, ЭМЯ, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан болон холбогдох бусад байгууллагууд</p>	<p>Зурагт хуудас, ухуулах хуудас, тараах материал зэрэг хэвлэлийн материалууд ЭМЯ, Төслийн цахим хуудас , төслийн фэйсбүүк хуудас.</p> <p>Зорилтот газруудад олон нийтэд зарлах</p>

	Хязгаарлагдм ал/ эмзэг бүлгүүд		Хос /монгол, казах/ хэл дээр хэвлэгдсэн сурталчилгааны хуудас, ухуулах хуудас, тараах материал, брайль хэвлэмэл материал

Буруу ташаа мэдээлэл олон нийтийн дунд хурдан тархах магадлал өндөр байна.

Вакцины үр нөлөө, гаж нөлөөний талаарх ташаа мэдээлэл, вакцины хуваарилалт, байнгын ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг тогтмол хянах, вакцинтай холбоотой харилцаа холбоо, мэдээлэл түгээх, мэдлэг олгох бүхий л үйл ажиллагааг НЭМҮТ хариуцан үндэсний хэмжээнд зохицуулан ажиллаж байна. Тиймээс төсөл хэрэгжүүлэх нэгж НЭМҮТ-тэй гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөж байна.

Вакциныг түгээхэд аюулгүй байдлыг хангах үүднээс, онцгой байдлын байгууллага, тагнуул, цагдаагийн байгууллагууд тус бүртээ үүрэг хүлээн оролцож байна. НТХН эдгээр байгууллагын албан хаагчдад зориулан мэдээлэл, эрсдлийн үеийн харилцаа холбоо, авч хэрэгжүүлэх арга хэмжээний заавар, удирдамж боловсруулж сургаж чадавхжуулах, тараах материал бэлтгэн тараахаар төлөвлөж байна. Мөн НТХН-ээс оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө, өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хариу арга хэмжээ авах хэрэгслийн нэг болгож Олон нийттэй харилцах мэдээлэл сурталчилгааны стратеги боловсруулж байгаа бөгөөд тус баримт бичгийн салшгүй хэсэг юм.

Вакцинжуулалттай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийн хувьд нийт хүн амын вакцины мэдлэгийг дээшлүүлэх, оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөнд тусгагдсан эмзэг бүлэгт чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр НТХН төлөвлөгөөний төсөл бэлдэн 1-р бүрэлдэхүүн хэсгийн ажлын хэсгээр 2021 оны 1 сард хэлэлцүүлсэн ба холбогдох саналуудыг тусган шинэчилж байна.

Тус ажлын төлөвлөгөөнд НЭМҮТ, ЗӨСҮТ, ХӨСҮТ, ЭХЭМҮТ, Эрүүл Мэндийн Хөгжлийн төв (ЭМХТ) зэрэг төрийн байгууллагуудын санал болон төрийн бус байгууллагуудын төлөөллийн саналыг тусгасан болно. НТХН зарим гол тэргүүлэх чиглэлүүд нь төслийн үр шим хүртэгчдийн талаарх ойлголт, вакцин авахад тулгарч буй саад бэрхшээлийн талаар ажлын хэсгээр дамжуулж мэдээлэл авч тусгаж ажиллахаар эрмэлзэж байна. НЭМҮТ, ЭМХТ-тэй хамтран өвчний талаарх буруу ойлголт, вакцины танилцуулга, аливаа сөрөг ойлголтыг эсэргүүцэх, КОВИД-19 вакцины хөтөлбөрийн тойм, эрсдэлийн бүлгүүд, дагалдах хэрэгслийн олдоц, хүлээн авах шаардлагатай хүмүүсийг хянах хоёр дахь тунгийн тухай зэрэг вакцинтай холбоотой мэдээллийг цаг тухайд нь тараах зорилгоор эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

ДЭМБ-ын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох удирдамжийн дагуу КОВИД-19 вакцинжуулалтын тухай олон үе шаттай хөтөлбөрийн санхүүжилтийн тухай хуулийн дагуу вакцинжуулалтын эхний зорилт нь Монгол улсын хүн амын хамрагдах, эрүүл мэндийн ажилчдыг нэн тэргүүнд эрэмбэлнэ гэж үндэсний төлөвлөгөөндөө тусгасан. Хамгийн эмзэг бүлэгт эрүүл мэндийн ажилтнууд, мөн ахмад настан, хавсарсан өвчтэй хүмүүсийг багтаасан байна. Бүх хүмүүст вакцинжуулалтыг нэгэн зэрэг хийхгүй учраас мэдээллийг хангалтгүй эсхүл үр дүнгүй түгээх нь вакцинд үл итгэх эсхүл вакцины цогц арга хэмжээнд хүндрэл учруулж болзошгүй юм. НЭМҮТ төв олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг хийж,

хэн, хаана, хэзээ вакцинд хамрагдах талаарх мэдээллийг шуурхай түгээж, нийгмийн сүлжээн дэх дархлаажуулалтын эсрэг, сөрөг мэдээнд өгөх түлхүүр мэдээллийг урьдчилан боловсруулж түгээнэ.

Түүнчлэн НТХН нь холбогдох байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, олон нийтэд мэдээлэл түгээх, мэдлэг олгож зөв хандлага, дадал хэвшил бий болгох чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана. (i) эрүүл мэндийн ажилтнууд болон олон нийтийн сайн дурын ажилтнуудын сүлжээг хөгжүүлэх; (ii) зан үйлийн өөрчлөлтийн мессеж, олон нийтийн хөдөлгөөнийг идэвхжүүлэх, лабораторийн болон вакцины логистикт дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн олон нийтийн байгууллагууд, хувийн хэвшил, хувь хүмүүс, ашиг хүртэгчдийн санал хүсэлтийг хэрэгжүүлэх, (iii) Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөлтэй хамтран одоо байгаа цахим хуудсанд суурилсан иргэдийн платформыг ашиглах, (жишээлбэл: [www.1818.mn](http://www.1818.mn) эсхүл <https://covid19.mohs.mn/>), эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд түшиглэн зорилтот үр шим хүртэгчид болон улс орон даяар иргэдэд хүрэхийн тулд олон нийт болон Иргэний нийгмийн Байгууллага (ИНБ)-уудын сүлжээтэй хоёр талт харилцаа холбоог сайжруулах. (iv) Жендерт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) -ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн мессеж/эсхүл тэргүүн эгнээнд ажиллаж буй эрүүл мэндийн ажилчдын дунд, нэмэлт анхаарал шаардлагатай өвчтөнд үзүүлэх зохих үйлчилгээний талаар сургана.

### 3.4 Талуудын оролцоог хангах төлөвлөгөө

#### Хүснэгт 3: Зөвлөлдөх арга хэрэгсэл/суваг

Оролцогч тал/ зорилтот бүлэг	Зөвлөлдөх сэдэв	Зөвлөлдөх арга хэрэгсэл/арга зүй	Түгээх суваг/ давтамж, хугацаа	Хариуцах байгууллага
Бүх оролцогч тал  Үүнд Тусгай хэрэгцээт / эмзэг бүлгийн хүмүүс болон бүлгүүд, үндэсний цөөнхүүд багтана.	БОНУХ /ТОХТ -г сайжруулах болон хэрэгжүүлэх  Төслийн хэрэгжилтийн төлөвийг тогтмол шинэчлэх  Өргөдөл санал гомдлын байдал болон тоонд тогтмол дүгнэлт хийж, тэдгээрийг шийдвэрлэсэн эсхүл дараагийн шатанд илгээсэн тухай төлөвийг шинэчлэх  Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө (ХМТ) БОНУХ	Биеэр оролцох арга хэмжээ авахыг хориглосон учраас цахимаар зөвлөлдөх, санал авах  Төслийн цахим хуудас болон төслийн бусад олон нийтийн мэдээллийн сувгаар болон ЭМЯ-ны цахим хуудсаар төслийн баримт бичгийн төслийг хуваалцах  Өргөдөл гомдол шийдвэрлэх механизм ба үйл ажиллагааны талаарх постер / эсхүл ухуулах хуудсаар дамжуулж дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэх	-Хагас жилд нэг удаа тайлан гаргаж оролцогч талуудад хүрэх боломжтой сувгуудаар түгээх  - Санал гомдлыг улирал тутамд статистик мэдээ гарган оролцогч талуудад мэдээлэх	ЭМЯ/НТХН

	Олон салбарын харилцаа холбоо, зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх институцийн бодлого, төлөвлөгөө, журам, уялдаа холбоог сайжруулах	Цахим семинар, жижиг бүлгийн ярилцлага (онлайнаар байж болно)	-Хагас жилд нэг удаа тайлан гаргаж оролцогч талуудад хүрэх боломжтой сувгуудаар түгээх - Санал өргөдөл гомдлыг улирал тутамд статистик мэдээ гарган	ЭМЯ/НТХН
	Нийгмийн эрүүл мэндийн хуулийн хэрэгжилт	Судалгаа, санал асуулга, асуумж	оролцогч талуудад мэдээлэх	ЭМЯ/НТХН

### 3.5 Эмзэг бүлгийн оролцоог хангах нь

Эмзэг байдал нь тухайн хүний гарал үүсэл, хүйс, нас, эрүүл мэндийн байдал, эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал, нийгэм дэх хязгаарлагдмал эрх бүхий байдал (жишээлбэл, үндэстний цөөнх, алслагдсан бүс нутгийн иргэд), бусад хүмүүс эсхүл байгалийн баялгаас хараат байдал гэх мэтээс үүдэлтэй байж болно.

Эдгээр эмзэг бүлгийн иргэд нийгэм соёлын, ахуй амьдралын орчин нөхцөл ялгаатай, түүнчлэн эрүүл мэндийн шалтгаан, тусгай хэрэгцээний улмаас төслийн үр нөлөөг ойлгох, өөрийн асуудал, бэрхшээлээ илэрхийлэх боломж байхгүй эсхүл хязгаарлагдмал байдаг. Тэд үйлчилгээ авах, оролцогч талуудын үйл ажиллагаанд оролцоход бэрхшээлтэй байдаг учраас тэдний нөхцөл байдлыг ойлгох, энэ байдлыг нь бууруулахад чиглэсэн арга хэмжээ, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх боломжийг бий болгон бусад оролцогч талуудтай ижил түвшинд оролцоог нь хангаж ажиллана.

Дараах эмзэг бүлгийн хүмүүст Эрүүл мэндийн эсвэл нийгмийн ажилтнаар дамжуулж мэдээлэл дамжуулах, санал гомдлыг хүлээж авна. Мөн төслийн цахим хуудас болон утсаар холбогдож болно.

- Гэртээ эсвэл асрамжийн газарт байдаг өндөр настнууд;
- Архаг, хууч өвчтэй өвчтөн (АЗӨ, ЗСӨ, чихрийн шижин болон бусад)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эсхүл асрамжийн газар
- Түр хугацаагаар тусгаарласан эсвэл тусгаарлалтад байгаа хүмүүс
- Эх орондоо буцаж ирсэн хүмүүс
- Эрүүл мэндийн шалтгаанаас группэд орсон

Нутгийн иргэдтэй хэрхэн мэдээлэл дамжуулах, тэдний ёс заншил, онцлогт тохирсон харилцааны арга замуудын ТОХТ-д тусгаж өгөх талаар вакцинжуулалтыг эхлүүлэхээс өмнө илүү анхаарч ажиллах шаардлагатай.

Вакцинжуулалтын кампанит ажлыг нутгийн иргэдийн холбогдох байгууллагууд, эрх бүхий байгууллагуудтай түншлэх замаар явуулна. Вакцин нь заавал албадан хийж буй биш талаар зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлгийн үеэр тодорхой мэдэгдэх болно. Сонирхогч талуудын оролцоо, вакцинжуулалтыг КОВИД-19 дамжуулах эрсдэлийг багасгах, ялангуяа

алслагдсан бүс нутагт амьдардаг нутгийн иргэдийн хувьд сайн дурын үндсэн дээр тусгаарлагдах эрсдэлийг бууруулахын тулд нэмэлт урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Дараах эмзэг бүлгийн хүмүүст хороо, сумын нийгмийн ажилтнаар дамжуулж мэдээлэл хүргэх ба тэд манай төсөлтэй холбоотой санал гомдлоо мөн нийгмийн ажилтнаар дамжуулж илгээж болно. Мөн манай төслийн цахим хуудас болон утсаар холбогдож болно.

- Алслагдсан болон хязгаар нутагт (Дэд бүтэц байхгүй) амьдардаг иргэд, хүүхдүүд
- Нэн ядуу , хаягийн бүртгэлгүй (задгай гэсэн хаягтай) гар хороололд амьдардаг өрхүүд
- Өрх толгойлсон ганц бие эцэг, эх
- Эх орондоо буцаж ирсэн хүмүүс
- Хүүхдийн асрамжийн газар
- Орон гэргүй тэнэмэл амьдралтай хүмүүс
- Хязгаар нутагт байгаа улс хоорондын тээврийн жолооч

Үндэсний цөөнх болон тусгай хэрэгцээт хүмүүст зориулж Казак хэл дээр мэдээлэл бэлдэх, сонсголын болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулж дохионы хэл болон брайль үсгээр мэдээлэл бэлдэж түгээх. Тэдгээр хүмүүсийн олноор хамрагддаг холбоо нийгэмлэгийн шугамаар эргэн холбогдоно.

- Үндэстний цөөнх / Казак, Духа буюу цаатан /
- Тусгай хэрэгцээт хүмүүс эсхүл асрамжийн газар

#### 4. Талуудын оролцоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөөц ба үүрэг

##### 4.1. Нөөц

Эрүүл мэндийн яам нь НТХН-ээр дамжуулж оролцогч талуудын оролцоог хангах ажлыг хариуцна. Ашиг хүртэгч ба оролцогч талуудын оролцоо нь төслийн менежментийн үйл ажиллагааны үндсэн хэсэг юм. Үүний дагуу ТОХТ-г боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг төслийн менежментийн төсвөөс хэсэгчлэн санхүүжүүлнэ. КОВИД-19 төслийн 1.1-р хэсэг - Эрсдэлийн харилцаа ба олон нийтийн оролцоо төслийн хүрээнд нийт 1.1 сая ам.долларын төсөвт өртөгтэй нэмэлт санхүүжилт авах боломжтой.

Дэлхийн банкны ОУ-ын хөгжлийн ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Монгол Улсад коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэгт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын хэсгийг хэрэгжүүлэгч тал болох ЭМЯ байгуулсан.

ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10-р сарын 22-ны өдрийн А / 100 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын зөвлөх ахлан ажиллаж байгаа бөгөөд тус яамны дэргэдэх Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн өдөр тутмын үйл ажиллагааг ханган ажилладаг. Ажлын хэсэг болон НТХН тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нягт хамтран ажиллана.

ЭМЯ, НТХН-ээр дамжуулан талуудын оролцооны үйл ажиллагааг хариуцах бөгөөд орон нутгийн засаг захиргааны нэгж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэндийн ажилчид гэх мэт бусад байгууллагуудтай нягт уялдаатай ажиллах үүрэг хүлээнэ.

#### 4.2. Удирдлагын чиг үүрэг, хариуцлага

Одоогийн байдлаар ЭМЯ-ны хүчин чадалд үндэслэн яамны хэрэгжүүлж буй “Цахим эрүүл мэнд”(P126725) төсөл менежментийн баг төслийн үйл ажиллагааг бүх оролцогч талуудтай уялдуулах зохицуулах ажлыг хариуцан ажиллаж байна.

ЭМЯ-ны газар хэлтэс, харьяа байгууллага, аймгуудын эрүүл мэндийн газруудаар дамжуулан төслийн хэрэгжилт, түүний дотор ерөнхий зохицуулалт, үр дүнгийн хяналт хэрэгжилтийн талаар Дэлхийн банктай харилцах ажлыг хариуцах болно.

Эрүүл Мэндийн сайдаар ахлуулсан нэгдсэн Төслийн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь Нэгдсэн Төсөлд болон ЭМЯ-нд стратегийн бодлогын зөвлөгөө, удирдамж өгөх болон хяналт тавих болно. ТУЗ-ын гишүүнчлэлийг ЭМЯ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-үүдээс нэмэлт гишүүдээр өргөжүүлнэ. ТУЗ нь төслийн үйл ажиллагаа болон улсын онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө хоорондын уялдаа холбоог хангах үүрэгтэй. КОВИД-19-ийн хариу үйлдлийн олон салбарыг Шадар сайдаар ахлуулсан Засгийн газрын КОВИД-19 хариу арга хэмжээний хороог удирдан чиглүүлэх болно.

ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга нь төслийн захирлын үүргийг гүйцэтгэж, хяналт тавьж, төслийн хэрэгжилтийг ЭМЯ-ны холбогдох хэлтэс, албадтай хамтран зохицуулна. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төслийн зохицуулагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэжилтэн, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, эрсдэлийн харилцаа болон олон нийтийн оролцоог хангах мэргэжилтэн, санхүүгийн мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Талуудын оролцооны төлөвлөгөөний хэрэгжилтийг төслийн улирлын явцын тайланд баримтжуулан тайлагнана.

#### 5. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизм (ӨГШМ)

Төсөлтэй холбоотой санал, өргөдөл, гомдлыг Дэлхийн банкны өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизмын чиглэлээр баримталдаг бодлогын бичиг баримтад нийцүүлэн хүлээн авах, шийдвэрлэхэд дөхөм, өргөдөл гомдлын хүртээмжтэй механизмыг олон нийтэд нээлттэй байлгаж хэрэгжүүлнэ.

Төслийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх механизм нь өргөдөл, гомдлыг цаг тухайд нь, үр дүнтэй, талуудын сэтгэлд нийцсэн байдлаар шийдвэрлэхэд туслах зорилготой юм. Нөлөөлөлд өртсөн хүмүүст гомдол гаргах, төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй маргааныг шийдвэрлэх боломжоор хангаж итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, засаж залруулах үйл ажиллагааг хөнгөвчлөх, олон нийттэй зөвлөлдөх үйл явцын нэг хэлбэр юм.

##### 5.1 Өргөдөл гомдол шийдвэрлэх механизмын тодорхойлолт

Төсөл маргаан шийдвэрлэх уламжлалт механизмыг харгалзан дараах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ:

- Шударга, ил тод, тодорхой үр дүнд хүрэх;
- Ард түмний ёс заншилд нийцсэн, хүртээмжтэй байх ;
- Мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах
- Шүүхийн шүүн таслах ажиллагаанд хандахаас зайлсхийх ;

Өргөдөл гомдол шийдвэрлэх механизмыг дараах 2 чиглэлээр ангилан авч үзэж хэрэгжүүлнэ.

- i. Төслийн үйл ажиллагаатай холбоотой
- ii. КОВИД -19 эсрэг вакцинтай холбоотой

I. Төслийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол

Төсөл нийгэм, байгаль орчин, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж буй талаар оролцогч талууд санал, өргөдөл, гомдол ирүүлж болно.

Мөн Жендерт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар гомдол гаргаж болно. Жендерт суурилсан хүчирхийллийн талаарх гомдлыг аюулгүй, мэдээллийн нууцыг чанд хадгалж, ёс зүйтэй арга барилаар авч үзнэ. Мөн өргөдөл гаргагчийн зөвшөөрлөөр энэ талаарх аливаа гомдлыг төслийн зохицуулагч болон Дэлхийн банкинд нэн даруй мэдэгдэнэ. Төсөл хэрэгжүүлэх нэгж өргөдөл гомдлыг шийдвэрлэх боломжгүй нөхцөлд Дэлхийн банканд мэдээллийг хүргүүлж шийдвэрлүүлнэ.

- ii. КОВИД -19 эсрэг вакцинтай холбоотой өргөдөл гомдол

Энэ талаарх санал, өргөдөл гомдлыг энд заасан механизмаар хүлээн авч шийдвэрлэхгүй. Өөрөөр хэлбэл вакцины үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой санал гомдлыг Монгол Улсад вакцины талаар гомдол гаргах механизмын дагуу шийдвэрлэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны 7-р сарын 8-ны өдрийн А / 278 тоот тушаалаар дархлаажуулалтын дараах хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журам, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 8-р сарын 14-ны өдрийн Дархлаажуулалтын зөвлөх хорооны бүрэлдэхүүн, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох хорооны бүтцийн талаар батлагдсан А / 315 тушаал, 2021 оны 1-р сарын 11-ний өдөр батлагдсан Улсын Онцгой Комиссын 05 тоот тушаалын 3.10.14-т заасны дагуу дархлаажуулалтын дараах хүнд, ноцтой урвал, хүндрэлийг шалтгаан хамаарлыг тогтоох хороогоор хэлэлцүүлнэ.

Тиймээс учраас вакцины шалтгаан хамаарлыг тогтоох хорооны заавар, зөвлөмж мэдээллийг агуулсан цахим хуудасны холбоосыг НТХН цахим хуудаст байршуулна.

Вакцинтай холбоотой гомдлыг:

- ЭМЯ-ны цахим хуудас дахь гомдол хүлээж авах хэсгээр, <https://www.moh.gov.mn/app>
- 11-323002 утсаар,
- ХӨСҮТ-ийн цахим хуудасны гомдол хүлээж авах хэсэгт хандаж болох бөгөөд <https://www.nccd.gov.mn/index.php>
- Вакцинтай холбоотой мэдээлэл хүлээж авах, санал гомдол хүлээж авах 24 цагаар ажиллах утасны дугаарын мэдээллийг НТХН-ийн цахим хуудсанд байршуулах болно.

**Өргөдөл гомдол шийдвэрлэх тал:** Улсын хэмжээнд ЭМЯ, НТХН шийдвэрлэнэ. Өргөдөл гомдлыг хотын / бүсийн лавлагаа эмнэлэг тус бүрт болон улсын түвшинд ЭМЯ-наас байгуулагдах Өргөдөл гомдлыг барагдуулах хороогоор дамжуулан шийдвэрлэнэ.

**Өргөдөл гомдол гаргах хэлбэр:** Бичгээр илгээх, утсаар ярих, гар утасны мессеж илгээх, цахимаар мессеж бичих, НТХН-ийн цахим хуудасны гомдол санал гэсэн хэсэгт бичиж үлдээх, нийгмийн сүлжээнд байрлах төслийн хаягуудаар тус тус дамжуулан холбогдож болно.

**Өргөдөл гомдол хүлээж авах суваг:** ЭМЯ-аас бэлтгэн гаргасан олон нийтийн хэрэглээнд зориулсан цуврал мэдээлэл, эмнэлэг, клиникийн жагсаалт, тэдгээрийн холбоо барих утасны дугаарыг багтаасан цахим хуудсандаа байршуулсан.

НТХН нь төслийн ӨГШМ-ийн хэрэгжилт, тайлагналд чиглэсэн төслийн хэрэгжилттэй холбоотой гомдлыг шийдвэрлэх зорилгоор цахим хуудсандаа өргөдөл, гомдол хүлээн авах хэсгийг нээж, фэйсбүүк хуудас нээж чат-бот хөгжүүлэлт хийж эхлээд байна.

НТХН-ийн нэгдсэн цахим хуудсыг ЭМЯ-ны цахим хуудасны гомдлын хэсэг болон ХӨСҮТ-ийн гомдол саналын хэсэгт холбоно. Олон нийт НТХН-ийн цахим хуудасны гомдлын хэсгээр дамжин ЭМЯ-ны цахим хуудас руу шууд нэвтрэх боломжтой болно.

Гомдлыг дараах горимын аль нэгээр, шаардлагатай бол нэрээ нууцлах эсхүл гуравдагч этгээдээр дамжуулан шууд бүртгүүлэх боломжтой.

- +976 – 452672 (НЭМҮТ) эсхүл 119 дугаарын утсаар руу залгаж, КОВИД-19-тэй холбоотой гомдол гаргаж болно. КОВИД-19-ийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын холбоо барих жагсаалтыг <https://covid19.mohs.mn/p/cat/post/52> хаягаар орж харьяа орон нутгийн эмнэлэгтэй холбоо барьж болно.
- 1800-1200 руу залгаж "өргөдөл гомдол гаргах -6" гэсэн дотуур дугаарыг сонгож нийслэлийн Улаанбаатар хотод хамаарах гомдлыг мэдээлэх,
- info@moh.gov.mn эсхүл piu@ehr.mn хаягаар мэйлээр илгээх,
- Вакцинжуулалтыг сайжруулах талаар бүх шатны эрүүл мэндийн байгууллага, өрх, сум, дүүрэг, аймгийн эрүүл мэндийн байгууллага / сумдын эрүүл мэндийн төвд шууд захидлаар ирүүлэх,
- Эмнэлэг / эмнэлгүүдийн санал гомдлын хайрцаг, эрүүл мэндийн байгууллага дахь гомдлын дэвтэрт гомдлоо бүртгүүлэх,
- Цахимаар чатбот-д асуултаа илгээж автомат хариулагчаас мэдээлэл авах.

### **Өргөдөл гомдол шийдвэрлэх үе шат:**

Алхам 1: Гомдлыг хүлээн авч гомдлын дэвтэр эсхүл өргөдөл гомдлын талаархи мэдээллийн санд бүртгэнэ.

Алхам 2: Гомдлыг бүртгэснээс хойш эхний хариуг 48 цагийн дотор гомдол гаргагчид гомдол хүлээж авсан тухай мэдэгдэх

Алхам 3: Гомдлыг ажлын 3 хоногийн дотор НТХН-ийн холбогдох ажилтанд шилжүүлэх

Алхам 4: Гомдлыг судалж, 30 хоногийн дотор хариу мэдэгдэх

Алхам 5: Гомдлын хариу арга хэмжээ: Гомдлыг хаах эсхүл гомдол нээлттэй хэвээр байвал нэмэлт арга хэмжээ авна. Хэрэв гомдол нээлттэй хэвээр байвал гомдол гаргагч нь ЭМЯ-нд мэйлээр болон +976 - 323002, 119 дугаарын утсаар дамжуулан давж заалдаж болно.

Гомдол гаргагч нь санал болгож буй гомдлын шийдвэрт сэтгэл хангалуун бус байвал ӨГШМ нь давж заалдах боломжийг хангаж өгнө.

Боломжтой бүх арга хэмжээг санал болгосны дараа, гомдол гаргагч нь сэтгэл ханамжгүй байгаа бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995) -д заасны дагуу хууль ёсны давж заалдах эрхтэйг тэдэнд



мэдэгдэнэ. Хуулийн дагуу гомдлыг хүлээн авсан байгууллага 30 хоногийн дотор хариу өгөх боломжтой бөгөөд 30 хоногийн хугацаатай сунгах боломжтой.

Асуулт, хариултын хэсэгт тогтмол асуудаг асуулт, гомдлын дагуу асуулт хариулт боловсруулан байршуулна. Асуулт, хариултыг НТХН-ээс улирал бүр шинэчлэх бөгөөд бүх гомдлыг нэгтгэж, хүлээн авсан бүх гомдлын талаарх статистик мэдээллийг харуулах болно.

## 6. Хяналт, эргэх холбоо ба тайлан

### 6.1. Хяналтын үйл ажиллагаанд талуудын оролцоо

Энд танилцуулсан мэдээлэл хамгийн сүүлийн үеийн байх, тогтмол байх, төслийн үйл ажиллагааны хүрээнд тодорхойлсон оролцооны аргууд нь зохистой, үр дүнтэй байхын тулд төслийг хэрэгжүүлэх явцад ТОХТ-г тодорхой хугацаанд дахин шалгаж, шинэчилж байна. Төсөлтэй холбоотой үйл ажиллагаа болон түүний хуваарьт гарсан аливаа томоохон өөрчлөлтийг ТОХТ-д зохих ёсоор тусгах болно.

Вакцины хөтөлбөрийн бодит хэрэгжилтийг дэмжихийн тулд ИНБ-ын сүлжээд: (а) зорилтот бүлгүүд, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст дэмжлэг үзүүлэх, тэднийг аймгийн / оршин суудаг сумын хамгийн ойр байрлах эрүүл мэндийн байгууллагуудад бүртгүүлэх.; (б) зорилтот / үр шим хүртэгч бүлгүүдтэй харилцах харилцааг хөнгөвчлөх зорилгоор эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид, ИНБ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүнчлэн Улаанбаатар, аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөлтэй фокус бүлгийн хэлэлцүүлэг, олон талт уулзалтыг зохион байгуулж хөтөлбөрийн талаар мэддэг байх, цахим платформоор дамжуулан өгсөн мэдээлэлд нэвтрэх, эрүүл мэндийн анхан шатны эмнэлэг эсхүл бусад тогтоосон газарт очиж вакцин хийлгэж, хоёр дахь тундаа эргэж орох; (с) вакцинжуулалтын хөтөлбөрийг дэмжих үндсэн ажлуудыг гүйцэтгэхэд сайн дурын сүлжээ / эв санааны нэгдлийн санаачилгыг зохион байгуулж зорилтот үр шим хүртэгчид цаашлаад нийт хүн амд хүрч үйлчлэх ажлыг өргөжүүлэх.

### 6.2. Талуудад эргэн мэдээлэх

Талуудын оролцоог хэрхэн хангасан тэр дундаа эмзэг бүлгийн оролцоог хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, олон нийтийн санал гомдол, хүсэлтийн тоо, төрлийн талаарх мэдээллийн хураангуйг улирал бүр гаргаж түүнд үндэслэсэн үр дүнтэй арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

Мөн энэ талаар улирал бүр тойм тайлан НТХН бэлтгэн төсөл хэрэгжүүлэх удирдлагын түвшинд танилцуулан хэлэлцэж тайлангийн мөрөөр авч хэрэгжүүлэх, засаж сайжруулах арга хэмжээ авна.

Төсөл оролцогч талуудтай хэрхэн харилцан уялдаатай ажилласан тухай бие даасан тайланг хагас жилд нэг удаа бэлтгэн хүргүүлж мэдээлнэ

Гүйцэтгэлийн хэд хэдэн гол үзүүлэлтүүдийг (ГГҮ) дараах шалгуурын дагуу төслөөс тогтмол хянана:

- ✓ Төсөлтэй холбоотой олон нийтэд ил болгосон мэдээлэл, зөвлөлдөх уулзалтын тоо;

- ✓ Хүлээж авсан ба барагдуулсан өргөдөл, гомдлын тоо;
- ✓ Сүүлийн зургаан сарын хугацаанд КОВИД-19 вакцины дараалал, КОВИД-19 вакцинжуулалтын зорилтот бүлгүүд, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тараасан олон нийтэд түгээсэн мэдээлэл, зөвлөмжийн тоо ;
- ✓ ЭМЯ-аас батлагдсан протоколын дагуу КОВИД-19 вакцинжуулалт, халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиглэлээр бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтнуудын тоо;